# ХӨВСГӨЛ АЙМГИЙН
# ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 20 өдөр | Дугаар А/34 | Цагаан-Уул сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих ажлын техникийн тодорхойлолт боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ахлагч: П.Отгонбат (Хөдөлмөр халамж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд: Ш.Эрдэнэцэцэг (Санхүүгийн албаны дарга)
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат (Татварын Улсын байцаагч)

2. Ажлын даалгавар боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчид танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (П.Отгонбат)–д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д даалгасугай.

ДАРГА С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/